



ДУНДГОВЬ АЙМАГ
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 4/49

Мандалговь

Спортын бага олимп зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5"а", Төсвийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын 2.1.6, Сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 3.3.18 заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн багийн спортын төрлүүдийг хөгжүүлэх, бүх нийтийн биеийн тамирыг өрнүүлэх, иргэдийн бие бялдрын хөгжлийг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах, спортоор дамжуулан хүүхэд залуучуудын эерэг хүмүүжил, төлөвшлийг хангах, спортоор хичээллэгсэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор сумын Спортын бага олимпыг зохион байгуулсугай

2.“Спортын бага олимп”-ыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: О.Баярсайхан (Засаг даргын орлогч)

Гишүүд: М.Алтанчимэг (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

О.Сэрээтэр (Мандал багийн засаг дарга)

Л.Батсугир (Хэвлэл, мэдээлэл хариуцсан ажилтан)

Ц.Энх-амар (ЭДЦСургуулийн биеийн тамирын багш)

Б.Цэгимд (ГИЦСургуулийн биеийн тамирын багш)

Ж.Тогоохүү (Хүмүүнлэг сургуулийн биеийн тамирын багш)

Г.Цацралболд (Цэгц билиг сургуулийн биеийн тамирын багш)

П.Ууганбаяр (Мандал сургуулийн биеийн тамирын багш)

3.Спортын бага олимпыг олон төрлүүдээр чанартай зохион байгуулах иргэдийг хамруулахыг ажлын хэсгийн ахлагч (О.Баярсайхан)-д үүрэг болгосугай

4.Дээрх арга хэмжээнд шаардагдах 2905000 (Хоёр сая есөн зуун таван мянга) төгрөгийг засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Тамгын газрын дарга (Б.Оюунчимэг), ня-бо (О.Бямбасүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Р.МӨНХТОГТОХ